

БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АЛБАНЫ 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон тоо: Албаны дарга улсын ахлах байцаагч 1, улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч, нягтлан бодогч 1, улсын байцаагч нярав, бичиг хэрэг 1, улсын байцаагч 1 орон тоотойгоор ажиллаж байна.

Ил тод байдлын хүрээнд: Холбогдох хууль, журмын дагуу шилэн дансны нэгдсэн системд 2017 оны төсөв, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2017 оны 1-06 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, төсвийн тодотгол болон бусад холбогдох мэдээллийг нийтэлсэн.

Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын нэр, лого, эрхэм зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын мэдээлэл, 2017 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийн ил, тод байдал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, бусад цаг үеийн мэдээ мэдээллийг байгууллагын мэдээллийн самбаруудаар нийтэлсэн.

Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах зорилгоор албан хаагчдын мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчилсэн. Мөн Bulgan.gov.mn вэб сайтад хяналт шалгалтын график, 2016 оны тайланг байршуулсан ба sankhuu.audit.bu нүүр номонд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Сангийн сайдын 2017 оны 13 дугаар тушаал, хяналт шалгалтын график мэдээлсэн ба ABLE-ээр 16 сум 1 тосгонд 2016 онд шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөвлөмж, шилэн дансанд мэдээлэл байршуулах байдлын албан бичгийг хүргүүлэв.

ХОЁР. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Орон нутгийн төр захиргааны байгууллагын шийдвэр гаргуулсан байдал: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал, Засаг даргын Зөвлөлийн хуралд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал, 2016 оны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил цаашид анхаарах асуудлууд, Сум хөгжүүлэх сангийн зээлийн зориулалт үлдэгдэл, хугацаа хэтрэлтийн талаар мэдээлэл хийж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж гаргуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийн байдлын судалгаа гарган аймгийн Засаг даргын 01/149 тоот албан бичгээр бүх сумдад хүргүүлэв.

2017 онд хяналт шалгалт хийх хяналтын график батлуулав. Зөрчлийн ангиллын судалгааг сүүлийн 3 жилээр нэгтгэн Санхүү төрийн сангийн хэлтэст, 2016 онд илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөвлөмж, Шилэн дансны нэгдсэн вэб сайтад мэдээлэл байршуулсан байдалд дүгнэлт хийх тухай албан бичгийг аймгийн бүх сумдад хүргүүлээ.

Сумдын ИТХ-ын дарга,нарийн бичгийн дарга, Тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга нарт Шилэн дансны холбоотой дүрэм журмын хэрэгжүүлэх, хяналт тавих талаар сургалт зохин байгуулахад 450 гаруй хүн хамрагдсан.

ШШГА-тай 2016 онд тогтоогдсон Хишиг-Өндөр сумын Сум дундын эмнэлгийн нягтлан бодогч асан Мөнх-Эрдэнийн 5577,4 мянган төгрөгийн төлбөр барагдуулах гэрээ байгуулав.

Захиргааны хэргийн Шүүх, Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2015, 2016 онуудад хууль бус шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын судалгаа гаргуулан авав.

Байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр: Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлийн програмд мэдээллийн бааз үүсгэн оруулсан бөгөөд аймаг дахь төрийн албаны салбар зөвлөл, Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүний нөөцтэй холбоотой шаардлагатай мэдээ, судалгааг цаг тухай бүрт нь гаргаж өгсөн.

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг төрөл бүрийн сургалт, семинарт хамруулсан. Үүнд:

Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын сургалтад 5 ажилтан,

Сангийн яам, Японы ЖАЙКА төсөл хамтран зохион байгуулсан “Дотоод аудитын сургалт” -д 1 ажилтан

Албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, ажлын үр дүнг үнэлэх, ажлын идэвх санаачлагыг нэмэгдүүлэх чиглэлээр: Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 2 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан.

Албан хаагчдын мэргэжлээрээ ажилласан жил, ажлын туршлага, амжилтыг нь харгалзан, болзол шаардлагыг хангасан 2 хүнийг Алтан гадас одонгоор, 1 хүнийг Сангийн яамны “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлон холбогдох материалыг зохих байгууллагад хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. 2016 оны үйл ажиллагааны үр дүнгээр 85,4 оноогоор үнэлүүлсэн.

Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд анхаарч, биеийн тамир, спортын хамтлагийг шинэчлэн байгуулж, ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх биеийн тамир, спортын тэмцээн, арга хэмжээнүүдийг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Албан хаагчдыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор долоо хоногт 2 удаа фитнесээр хичээллэж байна. Булган марафон 2017 уралдаанд 3 албан хаагч амжилттай оролцлоо. Бүх нийтээрээ хог цэвэрлэх, мод тарих, малчдад тусламж өгөх аян, математикийн улсын олимпиад Булган аймагт зохион байгуулагдах үеийн хандивын аянд тус тус идэвх санаачлагатай оролцлоо.

Архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах чиглэлээр: Архивын хууль тогтоомжийн дагуу архивын хадгаламжийн нэгж 14-ийг бүрдүүлэлтийг хийсэн. Албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн хэвлэмэл хуудсыг албан хэрэгт ашиглаж, байгууллагын албан хэргийг “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын дагуу хэвийн хөтлөн явуулж байна.

Тайлант онд 96 албан бичиг ирснээс 32 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 48 албан бичгийг холбогдох байгууллага, иргэнд хүргүүлсний 9 нь хариутай албан бичиг байсан.

2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар байгууллагын даргын Б тушаал 5-ыг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын холбогдох заалтуудад нийцүүлэн гаргасан байна.

2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 6 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног байна.

Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр: УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар, салбарын сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон нийт 22 тогтоол, шийдвэрийн 30 заалтыг хяналтад авч, байгууллагын жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Хяналтад авсан захирамжлалын биелэлтийг ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ABLE цахим хуудсаар хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Байгууллагын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр: Байгууллагын хамт олны шуурхайг 7 хоног бүрийн мягмар гаригт хийж, үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтанд танилцуулж, биелэлтэд хяналтад тавьж ажиллалаа.

Байгууллагын өдөр тутмын болон аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актуудыг албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Байгууллагын хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу зохих хугацаанд гаргаж өгсөн. Хяналт шалгалт эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх 25 мэдэгдэл хүлээн авч Шилэн дансанд бүртгэсэн.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулах чиглэлээр: Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу явуулж байна. 2017 оны 06 дугаар сарын 20-ны байдлаар санхүүгийн 2017 оны жилийн эцсийн болон нэгдүгээр

улирлын тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг 5 удаа гаргаж, хуулийн хугацаанд зохих байгууллагад хүргүүлэн баталгаажуулж ажилласан.

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу байгууллагын татвар, нийгмийн даатгалын тайланг сар бүр гаргаж, онлайнаар шивж цаасаар хүргүүлэн баталгаажуулсан. Байгууллагаас тайлант хугацаанд нийт 5 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлд 6788,5 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварт 24343,7 мянган төгрөг төлсөн.

Байгууллагын орлого, зарлагын гүйлгээг холбогдох стандартын дагуу бүртгэж, сар бүр төсвийн гүйцэтгэлийг гаргаж, материалын тайлан болон санхүүгийн тайланг улирал бүр гаргаж, Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулж ажилласан.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын 2017 оны төсвийн тодотгол, төлөвлөгөөний хуваарийг улирал, сараар гаргаж харьяалагдах дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн. 2017 онд батлагдсан 75253,0 мянган төгрөгийн төсөв дээр 12210,0 мянган төгрөгийн тодотгол хийгдэж 87463,0 мянган төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянаж, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж ажилласан. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу байгууллагын 2016 оны байдлаар нийт 35 нэр төрлийн 17142,4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоолсон бөгөөд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, нөөцийн ашиглалтын байдал, тооллогын дүнг нэгтгэн дүгнэлт гаргасан бөгөөд тооллогоор илэрсэн зөрчил дутагдал үгүй байна. Аймгийн Аудитын газраар байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, зөрчилгүй санал дүгнэлттэй ажилласан.

ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТААР

Санхүүгийн хяналт шалгалтаар: Тайлант хугацаанд 296294,8 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг засаж залруулах 80 заалт бүхий 13 албан шаардлага хүргүүлэн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 28542,7 мянган төгрөг, тухайн байгууллагад төвлөрүүлэх 168480,5 мянган төгрөг нийт 206,84,1 мянган төгрөгийн 63 акт тогтоосноос 7860,4 мянган төгрөг орон нутгийн төсөвт, 168480,5 мянган төгрөг тухайн байгууллагад төвлөрч, актын биелэлт 85,6 хувьтай, албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна. Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг нийт зөрчлийн дүнтэй харьцуулахад анхан шатны баримтгүй зарцуулсан буюу данс бүртгэлд тусгаагүй ажил гүйлгээ 151415,5 мянган төгрөг буюу 73,5 хувь, зориулалт бусаар зарцуулсан 2125,8 мянган төгрөг буюу 1 хувь, цалин хөлсийг илүү, дутуу олгосон 28450,3 мянган төгрөг буюу 13,8 хувь, өмч хөрөнгийг дутагдуулсан 10058,0 мянган төгрөг буюу 4,9 хувь, өр авлага үндэслэлгүй хаасан 5111,2 мянган төгрөг буюу 2,5 хувь, зээлдүүлж түр ашиглуулсан 8923,3 мянган төгрөг буюу 4,3 хувийг тус тус эзэлж байна.

Илэрсэн ноцтой зөрчил: Бүрэгхангай сумын төсвийн мэргэжилтэн 2016 онд нэмэлт санхүүжилтийн данснаас залруулгын гүйлгээ нэртэй гүйлгээг анхан шатны баримтгүйгээр

